



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

**Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон нийт 5,000,000.00 (таван сая) төгрөгийн балансын үнэ бүхий хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Ш.Энхтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000888



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 43 дугаар тогтоолын хавсралт

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элгэлэл	Үлдэгдэл өртөг	ТӨБЗГ-ын 2018 оны 467 дугаар тогтоолоор тогтоосон дээд үнэ	Худалдах дээд үнийн санал
1	Волкswagen, 32-43 УНЕ, суудлын тусгай зориулалтын, арал: WV1ZZZ2DZWNO12923	1998/2009	342,000	5,000,000.00	5,000,000.00	-	1,000,000	500,000
				5,000,000.00	5,000,000.00	-	-	500,000
Нийт дүн				(таван сая)			(нэг сая)	(таван зуун мянган)